


**ЦАР ТАХЛЫН
ҮЕД Ч БИД ЭСЭН
МЭНД ТӨРӨХ
ЭРХТЭЙ!**



**2021 ОНЫ
ЖИЛИЙН
ТАЙЛАН**

Агуулга

- 1** Байгууллагын танилцуулга
- 2** Ерөнхий Зохицуулагчийн мэндчилгээ
- 3** Сүлжээний хөтөлбөрүүд
- 4** 2021 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд



БИДНИЙ ТУХАЙ

МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ нь эмэгтэйчүүдийн хүний эрх, жендэрийн тэгш байдал, нийгмийн шударга ёсыг хангахын төлөө ажилладаг 19 байгууллагын гишүүнчлэлтэй, нийгэмд үйлчилдэг ашгийн бус, нам бус, төрийн бус байгууллага юм.

Сүлжээ нь анх 2000 оны Монголын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын IV чуулганы оролцогчдын санаачилгаар "Монголын эмэгтэйчүүдийн ТББ-ын Үндэсний Сүлжээ" нэртэйгээр байгуулагдсан.

Үйл ажиллагаагаа илүү өргөн хүрээтэй, үр дүнтэй болгох зорилгоор цар хүрээгээ тэлж, 2007 онд Сүлжээ нь анх удаа зохицуулах албатай болсон. 2011 оноос "МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ" болж, жендэрийн тэгш эрх, эмэгтэйчүүдийн хүний эрх, ардчиллыг хангах, нийгмийн шударга ёсны төлөө ажиллаж байна.

АЛСЫН ХАРАА

Жендэр, нас, шашин, бэлгийн баримжаа, намын гишүүнчлэл, угсаа гарал, газарзүйн байршил, нийгмийн статус, арьсны өнгө зэргээс үл хамааран, хүн бүр эрхэм чанараа мэдрэн, айх аюулгүй, дарамтгүй, эрх чөлөөтэй амьдран, авьяас билгээ хөгжүүлж, амьдралаа өөрөө зохиож, аз жаргалаа эрэлхийлэх тэгш боломжийг хангасан нийгмийг төлөвшүүлэх.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Нийгмийн бүх хүрээг хамарсан, олон нийтийн өргөн оролцоотой, ардчилсан, нээлттэй, зоримог, тууштай жендэрийн тэгш эрх, шударга ёсны төлөө үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх хүч болох явдал юм.



УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШУУД



С.Дондов

Иргэдэд туслах Хүний
эрхийн төв Тэргүүн



М.Цасчихэр

“Эрчүүд-Эрүүл гэр бүл” төв
ТББ, Тэргүүн



Болормаа

Эмэгтэй удирдагч сангийн
Тэргүүн



Сарай

С.Айнагүл

Казах эмэгтэйчүүдийн
“Арулар” холбооны Тэргүүн



Ц.Бүжидмаа

Либерал Эмэгтэйчүүдийн
Оюуны Сангийн Тэргүүн



Н.Баярсайхан

“Хил хязгааргүй алхам”
ТББ-ын Тэргүүн




Х.Номингэрэл

“Өөрчлөлтийн төлөөх
эмэгтэйчүүд” ТББ, УЗ-ийн
дарга



Б.Оюундарь

“Хөөрхөн зүрх” ТББ,
Зохицуулагч



Н.Биндэръя

“ДемоКрейзи залуусын төв”
Зохицуулагч

ЗОХИЦУУЛАХ АЛБА



Д.Энхжаргал
Ерөнхий зохицуулагч



Д. Должинсүрэн
Хөтөлбөрийн менежер



Т.Наранцэцэг
Санхүү/Захиргааны ажилтан



Г. Тэлмэн
Мэдээлэл/Гадаад харилцааны
ажилтан

Та бүхэнд МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээний 2021 оны тайланг толилуулж байгаадаа баяртай байна.

Цар тахал, хаалттай хөл хорионы үе нь бидэнд томоохон сорилт болсон ба урьдчилан таамаглаагүй, гэнэтийн нөхцөл байдалтай тулгарч, цахим орчинд, гэрээсээ ажиллах, шинэ үр чадварт суралцах зайлшгүй шаардлагыг бий болгосон.

Иймд бид 2021 онд хүний эрхийн болзошгүй ухралтаас сэргийлэх, яаралтай хариу үйлдэл үзүүлэхэд нөлөөлөх чадавхиа бэхжүүлэхэд зорьж ажиллалаа.

ИНБ-дын залуу, эмэгтэй активистууд болон Сүлжээний гишүүн байгууллагуудын нөлөөллийн чадавхийг бэхжүүлж, бодлогын шийдэл шаардсан асуудлаар нэгдсэн ойлголт, нэгдмэл байр сууринд хүргэх суурийг тавихад анхаарлаа хандууллаа.

Бид нийтлэг зорилготой бусад сүлжээ, эвсэл, холбогдох талуудтай олон талын оролцоо, хамтын ажиллагааг уялдуулж, collaborative public policy-д нөлөөлөх орон зайг тэлэхийг зорьлоо.

Энэ хүрээнд бид:

- Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын нөлөөллийн чадавхыг бэхжүүлэх: Хүний эрх, ардчилал, хуулийн засаглал, нийгмийн шударга ёс, жөндөрийн тэгш байдал, хүний эрхэд суурилсан хандлага, тэгш хүртээмж (inclusion), ялгаатай байдал (diversity) зэрэг суурь зарчим, үзэл баримтлалын талаар нэгдсэн ойлголттой болох;
- Raise public awareness and advocate for priority issues: Анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай, цаг үеийн тулгамдсан асуудлыг сонгон авч ИНБ-дын холбогдох Сүлжээ, Эвслүүдтэй хамтарсан нөлөөллийн кампанит ажил өрнүүлэх;
- Бодлогын шийдэл шаардсан асуудлуудад олон нийтийн дэмжлэг авах, шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх нэгэн суваг болгох зорилгоор онлайн активизм өрнүүлэх;
- Бодлогын асуудлаар олон талт оролцогчдын цуврал хэлэлцүүлэг өрнүүлэх (a series of multi-stakeholder dialogue): УИХ-аар хэлэлцэх гол хуулиуд болон шийдэл шаардсан бодлогын асуудлуудыг сонгон авч хамтын манлайллыг бэхжүүлэхэд анхаарч ажиллалаа.



Цар тахлын амаргүй цаг үед бидний санаачилгыг дэмжсэн бүх санхүүжүүлэгч, хамтрагч нартаа баярлалаа. Нэг баг болж хамтран зүтгэсэн Гишүүн байгууллагууд, Зохицуулах албаны хамт олондоо мөн талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн, Д.Энхжаргал,
МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээний
Ерөнхий зохицуулагч

"Эмэгтэйчүүдийн нүдээр" ээлжит чуулган



Чөлөөт, Амьд орон зай:

Мэдээлэл, мэдлэг, туршлага, сургамжаа хуваалцах, харилцан суралцах үйл явцыг чухалчилдаг.

Олон нийтийн хараат бус индэр:

Орхигдуулж эсвэл гажуудуулж буй асуудлаар бодлогын олон талт өргөн хэлэлцүүлэг өрнүүлдэг.

"Аюулгүй сургууль"

Сургуулиудыг жендэрт суурилсан хүчирхийллээс ангид, харилцан хүндэтгэлтэй, хүүхэд, хүн бүрт ээлтэй, аюулгүй орчин болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.



Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх механизмыг сургуулийн орчинд бүрдүүлэх аргачлал

SASA! аргачлал



ЖСХ-ээс урьдчилан сэргийлэхэд орон нутаг, хамт олны (community) хүчийг дайчлахад чиглэсэн SASA! аргачлалын хандлага, зан үйлийн өөрчлөлтийн загвар. SASA! гэдэг нь нийгэм, орон нутаг, хамт олны хандлага, зан үйлийн өөрчлөлт бий болгох үйл явцын 4 үе шатыг нэрлэсэн нэрсийн товчлол:

1. Start/Эхлэл,
2. Awareness/Ухамсар,
3. Support/Дэмжлэг,
4. Action/Үйл хэрэг)

“Маскулинити/эр жендэр”

Хөвгүүд, эрэгтэйчүүдэд жендэрийн сөрөг дүрүүдэд баригдалгүй эрх чөлөөтэй оршиход дэмжлэг үзүүлэх; жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийгмийн олон бүлэг, ялангуяа хөвгүүд, эрэгтэйчүүдтэй хамтран ажиллах үндэсний чадавх бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.

ЖЕНДЭРИЙН ШУДАРГА ЁС БА МАСКУЛИНИТИ/ЭР ЖЕНДЭР





Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийг бүх нийтэд хүртээмжтэй болгох нь

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх нь хүн бүрийн амьдралын бүхий л цаг үе, мөчлөгтэй холбоотой салшгүй эрх юм. Иймээс аливаа ялгаварлал, дарамт, шахалт, албадлага, хүчирхийлэлгүйгээр шийдвэр гаргах, сонголт хийх мэдлэг, ур чадвар олгоход чиглэгдсэн бэлгийн цогц боловсролыг түгээх зорилготой.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, НӨЛӨӨЛӨЛ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдон ажиллаж байгаа эмэгтэй төлөөлөгчдөд хамтын манлайллын ур чадваруудыг эзэмшүүлж, нөлөөллийн чадавхыг дээшлүүлэх зорилготой



2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

1. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛЛЫН СҮЛЖЭЭ

“Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ, “МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ” ТББ-ын консорциумаас эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог бэхжүүлэх, сонгуульт албанд олон нийтийн итгэлийг хүлээн ажиллах, нийгмийн өөрчлөлтөд манлайлан оролцох хүсэл эрмэлзэлтэй эмэгтэйчүүдийг дэмжих зорилготой “Эмэгтэйчүүдийн Манлайллын Сүлжээ”-г зохион байгуулан ажиллаж байна.

Энэ сүлжээ нь БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА), НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд хэрэгжиж байна.

Эмэгтэйчүүдийн Манлайллын Сүлжээ нь манлайлагч эмэгтэйчүүдийг улс төрд татан оруулах, шийдвэр гаргах түвшний албан тушаалд горилох, улс төрийн сонгуульд нэр дэвших, улмаар иргэдийн итгэлийг хүлээн хүний эрхэд суурилсан, жендэрийн тэгш байдлын зарчимд нийцсэн, тогтвортой хөгжлийн зорилгыг тээсэн бодлогын санаачилгуудыг манлайлан ажиллахад шаардагдах мэдлэг мэдээлэл, ур чадвар, эв санааны нэгдэл, хамтын нөлөөллийн олон талт дэмжлэг үзүүлэх орчин, тулах цэг байх эрхэм зорилготой.



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛЛЫН СҮЛЖЭЭ

• Сүлжээний нээлт

Эмэгтэйчүүдийн Манлайллын Сүлжээ 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр нээгдсэн. Сүлжээ нь улс орон даяар Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжин ажиллах зорилготой.

• Цуврал вебинар

ДЭВШИХ ЗАМ цуврал вебинараар хоёр долоо хоног тутамд тогтмол Лхагва гариг бүр гишүүддээ зориулан, цахим уулзалт, хэлэлцүүлэг өрнүүлж, цаг үеийн болон гишүүдийн сонирхсон асуудлыг хөндөн хэлэлцэх зорилготой.

• Цахим Сэтгүүл

Сүлжээний гишүүдэд зориулсан "Дэвшлээ" сар тутмын цахим сонинг гаргаж, гишүүдэд хүргэсэн.

"Дэвшлээ" сонин нь Монгол Улсын хөгжил дэвшилд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, манлайллыг чухалчлан үздэг, шийдвэр гаргах түвшинд өөрсдийн дуу хоолойгоо хүргэж, хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзэлтэй эмэгтэйчүүдэд мэдлэг мэдээлэл, урам зоригийн түүх болон бодлогын сэдвүүдийг хүргэж байх зорилготой.

• "Эмэгтэйн түүх" сар тутмын зочинтой ярилцлага

"ЭМЭГТЭЙН ТҮҮХ" нь монголын нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж буй улс төрч эмэгтэйчүүдийн урам зоригтой түүхийг хуваалцах, талархах, улс төрч эмэгтэйчүүд таилцах, сүлжээгээ бэхжүүлэх, эв санаагаа нэгтгэх зорилготой.



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
МАНЛАЙЛЛЫН СҮЛЖЭЭ

ЭМЭГТЭЙН ТҮҮХ Newstory

МАНЛАЙЛЛЫН ТҮҮХЭЭ ХУВААЛЦЬЯ

Хэзээ: 2021.12.04.

Хэдэн цагт: 15:45 - 18:00

Хаана: PEACE TOWER 18 ДАВХАРТ

Хэнд: Зөвхөн сүлжээний гишүүдэд



Ц.ОЮУНГЭРЭЛ



А.АРИУНЗАЯА



З.НАРАНТУЯА



Б.МӨНХСОЁЛ

2. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭДИЙН ЗАСАГ, ЭРХ МЭДЛИЙН ТӨЛӨӨ ХӨДӨЛГӨӨН БЭХЖҮҮЛЭХ


11

Эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрхийг хангаж, эрх мэдлийг нэмэгдүүлэх феминист зарчим дээр суурилсан хөдөлгөөн өрнүүлэн бэхжүүлэх зорилгоор Цөм багийн гишүүд нь эмэгтэйчүүдийн олон янз төлөөллөөс бүрдэж байгаа ба бичил бизнес эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй, алслагдсан нутаг дэвсгэрт амьдардаг, өрх толгойлсон, ЛГБТИК, хүүхдээ асарч буй залуу ээжүүдэд хүрч ажилладаг 22 төрийн бус байгууллагын нэгдэл юм.

Цөм багийн гишүүд стратегийн цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулж, хөдөлгөөний стратеги төлөвлөлтийг хэлэлцэн баталсан.

Хөдөлгөөн нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх, эрх мэдэлд сөргөөр нөлөөлж буй дараах 4 асуудалд анхаарч ажиллана:


- Бичил, жижиг бизнест ээлгүй орчин
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд бүтэц сул, үнэлгээгүй хөдөлмөрийн ачаалал их
- Хөдөлмөрийн дарамт, мөлжлөг, ялгаварлан гадуурхал
- Охид, залуу эмэгтэйчүүд рүү чиглэсэн жендэрийн хэвшмэл ойлголт



“Хамтын манлайлал - Бодлогын түншлэл”

Суурь ойлголт гүнзгийрүүлэх цуврал сургалт

2021 оны 3-р сарын 2-5, 9-10-ны өдрүүд



3. "ХАМТЫН МАНЛАЙЛАЛ-БОДЛОГЫН ТҮНШЛЭЛ" ТӨСӨЛ

Нийгэмд тэгш бус байдал гүнзгийрч байгаа энэ үед биднээс системийн, бүтцийн өөрчлөлт хийхийг шаардаж байна. Энэ өөрчлөлтийг хувь хүн эсвэл нэг байгууллага дангаараа хийж чадахгүй. Бид өмнөхөөсөө илүү хамтарч, бие биенийгээ дэмжин, нөөц боломж, мэдлэг ур чадвараа нэгтгэн хамтын манлайллаар ажиллах шаардлага бий болж байна

Энэ хүрээнд нийтлэг зорилго, зарчим, үзэл баримтлал бүхий иргэний нийгмийн байгууллагууд нэгдэн тодорхой бодлогын асуудалд байр сууриа илэрхийлэх, дуу хоолойгоо хүргэх зорилгоор “Хамтын манлайлал-Бодлогын түншлэл” нөлөөллийн кампанит аянг амжилттай зохион байгуулсан.

Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын нөлөөллийн чадавхийг бэхжүүлэх энэ аянг МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ Бүгд Найрамдахчуудын Олон Улсын хүрээлэн IRI in Mongolia - БНОУХ дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн.



Эмэгтэйчүүд сонгогдох үедээ төдийгүй сонгогдсоны дараа ч олон тооны саад тотгоруудтай тулгардаг. Улс төрд хүчээ сорихыг хүссэн, улс төрд орсон эмэгтэйчүүдийн давуу тал, боломж нь хувь хүнийхээ түвшинд байгаа бол сорилт, хязгаарлалт нь тогтолцооны шинжтэй байна.

Нийгмийн тогтсон хэм хэмжээ буюу одоогийн байгаа байдлыг хэвээр хадгалах бус харин улс төрийн үйл явцад илүү үр дүнтэй оролцохын тулд Иргэний нийгмийн байгууллагын ажилтнууд хамтын манлайллын шинэлэг загварт суралцах шаардлага бий болж байна.

Иймээс улирал тутам бодлогын асуудлаар олон талт оролцогчдыг хамруулсан 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Цуврал сургалт

Нэгдсэн ойлголтод хүргэх, нөлөөллийн чадавх бэхжүүлэх 2 удаагийн сургалтыг Иргэдийн хурлын төлөөлөгч эмэгтэйчүүдэд зохион байгууллаа. Сургалтаар:

- бусдыг сэдэлжүүлэх
- үйл хэрэгтээ татан оролцуулах
- нөлөөллийн хүрээгээ бэхжүүлэх
- иргэдийн оролцоог баталгаажуулсан шинэ хууль тогтоомжуудыг хэрэглэх зэрэг хамтын манлайллын ур чадваруудыг эзэмшүүлээ.

Уг сургалтыг МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгээс хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан.

Суурь ойлголт гүнзгийрүүлэх цуврал сургалт

2021 оны 3-р сарын 2-5, 9-10-ны өдрүүд





4. SASA! Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд нийгэм, хамт олныг дайчлах, олон нийтийн оролцоог үр дүнтэйгээр дэмжих аргачлал

Баянхонгор аймагт охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд нийгэм, хамт олныг дайчлах, олон нийтийн оролцоог үр дүнтэйгээр дэмжих SASA! аргачлалыг хэрэгжүүллээ.

Уг хөтөлбөрөөр Баянхонгор аймагт:

- SASA! Аргачлалыг хэрэгжүүлэх цөм багийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан.
- Активистуудыг арга зүйн удирдамжаар хангаж, орон нутгийн активизм өрнүүлэх гарын авлагыг боловсруулсан.
- Активистуудын санаачилгад аргазүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

Бэлтгэгдсэн активистууд орон нутаг, хамт олныхоо хүрээнд охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох санал, санаачилга гаргаж, нэг стратеги, нэгдмэл зохион байгуулалтайгаар орон нутгийн активизмыг өрнүүлж байна.

Энэ үйл ажиллагааг Баянхонгор аймгийн Засаг Даргын Тамгын газар, НҮБ-ын Хүүхдийн сан/UNICEF Mongolia -гийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн хүрээнд зохион байгууллаа.

#активист гэж хэн бэ?



- Нийгэм, эргэн тойронд ямар нэгэн зүйл болохгүй байгааг мэдэрдэг.
- Үүсээд буй асуудлыг хувь тавилан гэж хүлцэн тэвчээд суудаггүй.
- Хэзээ нэгэн цагт энэ зүйл шийдвэрлэгдэнэ гэж хүлээдэггүй.
- Өөрийнхөө зүгээс хийж чадах хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг хүн



Эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр ажилладаг Төрийн бус байгууллагуудтай хамтран "Өргөө" амаржих газар “дөнгөж төрсөн эхийг нярайн хамт зөөвөрлөх” үед хүнлэг бус хандсан явдлыг буруушааж, Ковид 19 цар тахлын үед жирэмсэн болон төрөх эмэгтэйчүүдэд ээлтэй нөхцлийг шаардсан нөлөөллийн цахим акци өрнүүллээ.

Тус акцын хүрээнд Ковид 19 цар тахлын үед Засгийн газар, Улсын Онцгой Комисс, Эрүүл Мэндийн Яамнаас гаргаж буй шийдвэрүүд нь жирэмсэн болон төрсөн эхчүүдэд хэрхэн нөлөөлж буйд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан. Уг дүгнэлт, зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий Сайд Л. Оюун-Эрдэнэ, Эрүүл мэндийн сайд С. Энхболд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын Генерал Г. Ариунбуян нарт тус тус хүргүүллээ.



**КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД
ЖИРЭМСЭН БОЛОН ТӨРӨХ
ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЭЭЛТЭЙ
НӨХЦЛИЙГ ШААРДАЖ БАЙНА!**





МОНФЕМНЕТ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

Уг тайлантай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл:



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, Нэгдэлчин зочид буудлын “Апартмент-96” өргөтгөл, 2 давхар, 202 тоот



+976 7011 0355



www.monfemnet.org



MONFEMNET National Network